

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ДУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/164/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхтулга Утас: 70432545 цахим хаяг: Tunkhtulga.d@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<i>СТА</i>	<i>Санхүүгийн тайлангийн аудит</i>

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	15
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..	Error! Bookmark not defined.
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	15
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	16

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цэмбегараа баг, Жаргалант сум, Ховд
Утас: 975-70433081, факс: 975-70433081
E-mail: khovd@audit.gov.mn

ДУУТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ЭРДЭНЭХИШИГ ТАНАА

2021.02.08 № 4/37
тантай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дуут сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дуут сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.


Аудитаар Дуут сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>18,706,074.00</u>	<u>27,934,000.00</u>
33	АВЛАГА	7,895,000.00	21,345,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	4,330,000.00	3,280,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	7,000,000.00
335	Бусад авлага	3,565,000.00	11,065,000.00
3351	Байгууллагаас авах авлага	3,565,000.00	11,065,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	10,811,074.00	6,589,000.00
354	Хангамжийн материал	10,811,074.00	6,589,000.00
35410	Бичиг хэргийн материал	20,000.00	-
35420	Аж ахуйн материал	9,625,574.00	4,621,500.00
35470	Бусад хангамжийн материал	1,165,500.00	1,967,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,442,107,550.89</u>	<u>2,255,062,991.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,442,107,550.89	2,255,062,991.20
392	Биет хөрөнгө	1,394,684,050.89	2,208,169,741.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,227,085,642.00	1,291,222,657.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(45,070,108.60)	(78,616,217.20)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	155,694,660.00	155,694,660.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(52,428,023.36)	(76,811,346.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,116,822.00	178,091,885.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(119,050,977.16)	(125,816,157.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,420,522.00	40,735,964.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,690,229.46)	(27,992,519.02)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	802,370,023.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	230,952,321.00	238,952,321.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(168,346,577.53)	(189,661,528.44)
393	Биет бус хөрөнгө	47,423,500.00	46,893,250.00
39301	Програм хангамж	3,316,000.00	3,316,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,382,500.00)	(1,912,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	45,490,000.00	45,490,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II	<u>1,460,813,624.89</u>	<u>2,282,996,991.20</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>7,000,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	7,000,000.00
413	Өглөг	-	7,000,000.00
4136	Бусад өглөг	-	7,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	7,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,460,813,624.89</u>	<u>2,275,996,991.20</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,460,813,624.89	2,275,996,991.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	789,978,135.00	789,978,135.00
512	Хуримтлагдсан үр дүн	427,878,011.62	1,243,061,377.93
51210	Өмнөх үеийн үр дүн	427,878,011.62	427,878,011.62
51220	Тайлант үеийн үр дүн	-	815,183,366.31

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	242,957,478.27	242,957,478.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,460,813,624.89	2,282,996,991.20

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	403,133,379.00	1,330,410,043.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,128,414.00	904,059,463.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,128,414.00	904,059,463.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,128,414.00	904,059,463.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,523,414.00	903,454,463.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,004,965.00	426,350,580.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,112,065.00	81,745,580.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	86,792,817.00	76,915,074.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,433,748.00	4,188,506.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,885,500.00	642,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	294,892,900.00	344,605,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	278,655,100.00	337,165,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	16,237,800.00	7,440,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	406,209,431.60	515,201,676.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	406,209,431.60	515,201,676.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	400,975,149.60	491,867,831.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,661,751.00	222,630,755.00
210101	Үндсэн цалин	178,433,218.00	205,039,007.00
210102	Нэмэгдэл	76,540.00	17,591,748.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,151,993.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,569,028.00	27,941,362.00
210201	Тэтгэврийн даатгал	15,780,280.19	19,351,230.41
210202	Тэтгэмжийн даатгал	1,790,137.11	2,263,733.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,432,109.71	1,810,986.98
210204	Ажилгүйдлийн даатгал	324,227.37	410,229.76
210205	Эрүүл мэндийн даатгал	3,242,273.62	4,105,181.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,024,532.00	23,462,150.00
210301	Гэрэл, цахилгаан	20,207,914.00	15,901,536.00
210302	Түлш, халаалт	1,816,618.00	7,560,614.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,679,228.60	33,843,478.00
210401	Бичиг хэрэг	5,428,500.00	4,124,690.00
210402	Гэвэр, шатахуун	14,503,674.60	14,951,580.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,402,054.00	1,736,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,345,000.00	4,514,674.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	8,515,734.00
2105	Нормативт зардал	360,600.00	145,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	360,600.00	145,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,212,017.00	59,501,074.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	530,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	243,100.00	-
210604	Урсгал засвар	30,968,917.00	58,971,074.00
2107	Томилолт, зочны зардал	5,264,840.00	1,232,000.00
210702	Дотоод албан томилолт	5,264,840.00	1,232,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,844,275.00	21,638,242.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,994,505.00	21,317,282.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,000.00	69,960.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,160.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	164,610.00	4,000.00
210807	Газрын төлбөр	138,000.00	147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	88,358,878.00	101,473,170.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,016,253.40	9,096,910.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,342,624.60	92,376,260.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,234,282.00	23,333,845.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	220,000.00	18,161,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	17,941,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	220,000.00	220,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,172,845.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,172,845.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,014,282.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,014,282.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(3,076,052.60)	815,208,366.25
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,070,924.98	24,999.94
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,070,924.98	24,999.94
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,070,924.98)	(24,999.94)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(5,146,977.58)	815,183,366.31

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	388,535,965.00	426,955,580.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,505,000.00	605,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,505,000.00	605,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	605,000.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
120009	Бусад орлого	900,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	387,030,965.00	426,350,580.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,138,065.00	81,745,580.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	86,792,817.00	76,915,074.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,433,748.00	4,188,506.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,911,500.00	642,000.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	294,892,900.00	344,605,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	278,655,100.00	337,165,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	16,237,800.00	7,440,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	386,882,465.00	426,955,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,882,465.00	426,955,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,083,183.00	396,621,735.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	184,388,431.00	218,860,655.00

210101	Үндсэн цалин	127,825,160.00	143,404,157.00
210102	Нэмэгдэл	28,069,548.00	42,277,557.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,493,723.00	33,178,941.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,430,762.00	29,998,000.00
210201	Тэтгэврийн даатгал	15,112,456.00	21,109,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,649,759.00	2,222,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,253,530.00	1,777,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	313,355.00	444,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,101,662.00	4,444,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,024,532.00	22,520,900.00
210301	Гэрэл, цахилгаан	20,207,914.00	15,901,536.00
210302	Түлш, халаалт	1,816,618.00	6,619,364.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,814,748.00	19,983,640.00
210401	Бичиг хэрэг	5,054,916.00	2,860,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,360,728.00	14,026,540.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,399,104.00	3,097,000.00
2105	Нормативт зардал	402,000.00	290,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	290,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,461,417.00	64,736,274.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	51,300,000.00	5,192,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	30,961,417.00	59,394,074.00
2107	Томилолт, зочны зардал	5,302,840.00	1,232,000.00
210702	Дотоод албан томилолт	5,302,840.00	1,232,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,069,453.00	17,924,966.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,137,293.00	16,777,966.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,000.00	260,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,160.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	138,000.00	147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,189,000.00	21,075,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,189,000.00	21,075,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,799,282.00	30,333,845.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	220,000.00	18,161,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	17,941,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	220,000.00	220,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,172,845.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,172,845.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	8,579,282.00	7,000,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	8,579,282.00	7,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,653,500.00	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,653,500.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,653,500.00	-

2200	Дотоод эх үүсвэрээр	1,653,500.00	-
222001	Тоног төхөөрөмж	1,653,500.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,653,500.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,978,135.00	242,957,478.27	427,878,011.62	1,460,813,624.89
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	789,978,135.00	242,957,478.27	427,878,011.62	1,460,813,624.89
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,978,135.00	242,957,478.27	427,878,011.62	1,460,813,624.89
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	789,978,135.00	242,957,478.27	427,878,011.62	1,460,813,624.89
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	789,978,135.00	242,957,478.27	427,878,011.62	1,460,813,624.89
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	815,183,366.31	815,183,366.31
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	789,978,135.00	242,957,478.27	1,243,061,377.93	2,275,996,991.20

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	345,210,000.00	340,679,155.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	345,210,000.00	340,679,155.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	327,049,000.00	322,518,155.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	221,603,600.00	218,860,655.00
210101	Үндсэн цалин	148,466,300.00	143,404,157.00
210102	Нэмэгдэл	40,237,800.00	42,277,557.00
210105	Гэрээт ажлын хөлс	32,899,500.00	33,178,941.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,998,000.00	29,998,000.00
210201	Тэтгэврийн даатгал	21,109,700.00	21,109,700.00

210202	Тэтгэмжийн даатгал	2,222,100.00	2,222,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,777,700.00	1,777,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	444,500.00	444,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,444,000.00	4,444,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,520,900.00	22,520,900.00
210301	Гэрэл, цахилгаан	3,027,700.00	15,901,536.00
210302	Түлш, халаалт	19,493,200.00	6,619,364.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,469,000.00	18,451,000.00
210401	Бичиг хэрэг	2,848,100.00	2,848,100.00
210402	Тээвэр, шатахуун	12,505,900.00	12,505,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,115,000.00	3,097,000.00
2105	Нормативт зардал	290,000.00	290,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	290,000.00	290,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,660,800.00	5,942,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,192,200.00	5,192,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	150,000.00
210604	Урсгал засвар	1,268,600.00	600,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,541,600.00	1,232,000.00
210702	Дотоод албан томилолт	1,541,600.00	1,232,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,966,000.00	11,648,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,819,000.00	10,501,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	260,000.00	260,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00
210807	Газрын төлбөр	147,000.00	147,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,999,100.00	13,575,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,999,100.00	13,575,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,161,000.00	18,161,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,161,000.00	18,161,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,941,000.00	17,941,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	220,000.00	220,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	345,210,000.00	340,679,155.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	344,605,000.00	340,074,155.00
132001	Орон нутгийн төсвөөс	337,165,000.00	332,634,155.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	7,440,000.00	7,440,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	605,000.00	605,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	605,000.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	25
620001	Удирдах ажилтан	7	7
620002	Гүйцэтгэх ажилтан	8	8
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	7	7
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	25

650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	9
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	3	3
650010	Гэрээт ажилтан	7	7
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,138,065.00	81,745,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,138,065.00	81,745,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	92,138,065.00	81,745,580.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,244,748.00	1,532,640.00
210401	Бичиг хэрэг	-	12,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,244,748.00	1,520,640.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,392,817.00	58,794,074.00
210602	Тавилга	51,300,000.00	
210604	Урсгал засвар	29,092,817.00	58,794,074.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,500,500.00	13,918,866.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,500,500.00	13,918,866.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,500,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	7,642,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	7,642,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,138,065.00	81,745,580.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,138,065.00	81,745,580.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	92,138,065.00	76,915,074.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,188,506.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	642,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3.АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Дуут сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тамгын газрын дарга Б.Эрдэнэхишиг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч авлага, шатахууны зарцуулалт, и баримтын бүрдүүлэлтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 07-ноос 2021 оны 02 дугаар сарын 08-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

ЗДТГ нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай ил тод, тэгш хүргэж, Сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулж хүн ам, иргэддээ нийгмийн цогц үйлчилгээг бүрэн хүргэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулан, хувь хүмүүс өрх гэрүүдэд өөрийгөө тэтгэн хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- *Нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх*
- *Засгийн газрын шийдвэр харьяалах дээд шатны шийдвэрийг гүйцэтгэлийг хянах*
- *Тухайн шатны хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх*

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт*
- *Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай*

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дуут сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг 2016, 2017, 2018, 2019 оны үйл ажиллагаанд хяналт хийгдэж нийт 9313.9 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 6570.5 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт бичсэн байна.

Бичигдсэн 6570.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар орлогын гүйлгээг мэдээлээгүй байгааг мэдээлж ажиллах зөвлөмжийг өгсөн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “ИХ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 1236651.8 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 12366.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1330410.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 13304.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дуут сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 822183.37 мянган төгрөгөөр буюу 56 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	7,895.00	21,345.00	13,450.00	170%
Бараа материал	10,811.07	6,589.00	-4,222.07	-39%
Үндсэн хөрөнгө	1,442,107.55	2,255,062.99	812,955.44	56%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,460,813.62	2,282,996.99	822,183.37	56%
Богино хугацаат өр төлбөр	0	7,000.00	7,000.00	100%
Цэвэр хөрөнгө, өмч	1,460,813.62	2,275,996.99	815,183.37	56%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,460,813.62	2,282,996.99	822,183.37	56%

Авлага дансны үлдэгдэл 21345.0 мянган төгрөг болж 13450.0 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд аймгаас эрх шилжиж ирсэн худгийн ажлын эхний санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад өгсөн ч тайлант онд худгаа гаргаагүйтэй холбоотойгоор 7500.0, нэмэлт санхүүжилтийн данснаас сургуулийн бие засах газрын ажлын санхүүжилтийг төвлөрүүлсэнтэй холбоотой 7000.0 мянган төгрөгийн авлага нэмэгдэж цалингийн урьдчилгааны авлагыг 1050.0 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6589.04 мянган төгрөг болж 4222.07 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд эхний үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1442107.55 мянган төгрөг, оны эцэст 2255062.99 мянган төгрөгөөр болж 812955.44 мянган төгрөгөөр өссөн байна .

Үндсэн хөрөнгийн данс нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтаар 808944.3 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн, аймгийн хөрөнгө, ЗДТГ-ын дээврийн их засвар хийхтэй холбоотой 73262.4 мянган төгрөг, сумын ОНХС-гийн хөрөнгөөр 17000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж төсвийн хөрөнгөөр 6150.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч 905356.7 үндсэн хөрөнгө 905356.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Сумын ИТХ-ын 18 тоот тогтоолоор 19 нэр төрлийн 4559,1 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна. Үндсэн хөрөнгийн тайлант оны элэгдлийн зардал 412968.4 мянган төгрөг байна.

Өр төлбөр 7000.0 мянган төгрөг болж тайлант онд 7000.0 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн данснаас сургуулийн бие засах газрын санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад өгөлгүйгээр төсөвт төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2275996.99 мянган төгрөг болж тайлант онд 815183.37 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Дуут сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 927276.6 мянган төгрөгөөр буюу 230.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 927276.6 мянган төгрөгийн орлогоос 58509.9 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 887931.0 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдэж нэмэлт санхүүжилтийн орлого 10366.5 мянган төгрөгөөр, 8797.8 мянган төгрөгөөр ОНХС-гийн санхүүжилт буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 40073.1 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 34968.6 мянган төгрөг буюу 20.9 хувиар, тогтмол зардал 496.4 мянган төгрөг буюу 2.2 хувиар, бусад урсгал шилжүүлэг 17941.0 мянган төгрөг буюу 8.1 хувиар хангамж бараа материалын зардал 1168.9 мянган төгрөг буюу 6.2 хувиар тус тус өсөж эд хогшил, урсгал засварын зардал 17725,2 мянган төгрөг буюу 21.5 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 9144.8 мянган төгрөг буюу 33.7 хувиар, томилолтын зардал 7070.8 мянган төгрөг буюу 76.7 хувиар буурчээ. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 345210.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 345210.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 12/07 тоот тогтоолоор ЗДТГ-ын төсвийг төсөвт тодотгол хийж 345210.0 мянган төгрөгөөр баталжээ.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 344605,0 мянган төгрөгийн төсөв баталснаас 337165,0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 7440,0 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 605.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 337165,0 мянган төгрөг, ОНХС-аас 7440,0 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 344605,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 345210,0 мянган төгрөгийг зарцуулж 4530.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4530,8 мянган төгрөг буюу 100 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг 18,0 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардлыг 668,6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 317,9 мянган төгрөгөөр, дотоод томилолтын зардлыг 309,6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 423,8 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээ 2020.1 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой томилолтын зардал, хог хаягдал орчны бохирдлын арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	3181,6
80106	Баг хорооны үйл ажиллагааны зардал	756,1
80221	Бараа үйлчилгээний бусад зардал	160,0
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	95,0
82212	Хур хог хаягдал орчны бохирдол	177,7
80103	Ахмад настны хөгжил хамгаалал	160,3
	ДҮН	4530.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн хөрөнгө оруулалтаар Хөх бэлчир багийн Нарийн тошингийн амны гүүр, далан барих 19894.3, Ковид-19 цар тахлын санхүүжилт 1321.0 төгрөг, сургуулийн дээврийн засварт 9300.0 мянган төгрөг, эмнэлгийн засварт 30894.0 мянган төгрөг, ЗДТГ-ын дээврийн засварт 18599.0 худаг гаргахад 7500.0 мянган төгрөг, ОНХС-гаас 2000.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс 4067.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 420.0 мянган төгрөг, өвсний үнэ 642,0 мянган төгрөг, сургуулийн бие засах газрын үнэд 7000.0 мянган төгрөг нийт 81745.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс орон сууц хүн амын тооллого, хагас жилийн мал тооллогын судалгааны зардалд 1532.6 мянган төгрөг, урсгал засвар 58794.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 7500.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн 6276.8 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 7642.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 146 мэдээллээс хугацаандаа оруулсан 133 мэдээллийг хугацаандаа мэдээлж 13 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллага нь түүвэрт хамрагдсан бөгөөд ямар нэгэн алдаа илрээгүй байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 33440.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 20240.3 мянган төгрөгийн алдааг залруулж 13200.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар дараах алдаа зөрчлийг залрууллаа. Үүнд

- Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 7000.0 мянган төгрөгийн сургуулийн бие засах газрыг барих ажлын эхний санхүүжилтийг олгоогүй, авлага, өр төлбөрөөр бүртгээгүй байсныг авлага, өр төлбөрт залруулсан.
- ЗДТГ-ын хуучин байрны дээврийн их засварын ажлыг аймгаас ирсэн санхүүжилтээр орлогод тусгаж гэрээний үнээс 13240.3 мянган төгрөгөөр дутуу тусгаж ирүүлснийг үндсэн хөрөнгө болон үнэ төлбөргүй орлогын дансанд залрууллаа.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 13200.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар элэгдлээрээ өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломтой хөрөнгийг дахин үнэлэх асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлагын бүртгэл

1.1. **Илрүүлэлт:** Байгууллагын санхүүгийн тайланд өмнөх оноос шилжиж ирсэн 3280.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа дансны авлага байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, авлага төлөгдөхгүй удсанаас төлөгдөх найдвар багасаж төсвийн хөрөнгийг буцаан авч чадахгүйд хүрэх

1.2. **Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж цалингийн урьдчилгааны авлагыг 2021-04-25-ны дотор барагдуулан ажиллах

1.3. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

2. Бараа материалын бүртгэл

2.1. **Илрүүлэлт:** Тайлант онд тус байгууллага нь ЗДТГ-ын тээврийн хэрэгслээс өөр бусад тээврийн хэрэгсэлд хийсэн шатахууны тооцоо бодоогүй, жолоочийн замын хуудас бичүүлээгүй байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

2.2. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж тамгын газрын тээврийн хэрэгслээс бусад тээврийн хэрэгсэлд хийсэн шатахууны тайланг гаргаж жолоочийн замын хуудсыг бүрэн бичүүлж хэвших

2.3. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

3 Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

3.1 **Илрүүлэлт:** Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, захилгаар хийгдсэн судалгааны ажлуудад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар

баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

Эрсдэл: Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

3.2 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах.

3.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	Дуут сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ХОА-2021/164/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дуут сумын Засаг даргын тамгын газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх оноос дамжин ирсэн цалингийн урьдчилгааны авлагыг барагдуулан ажиллаагүй	3280.0	Зөвлөмж өгөх	Тамгын газрын дарга, нягтлан бодогч	Б.Эрдэнэхишиг Н.Ичинхорлоо
2	Байгууллагын авто машинаас бусад тээврийн хэрэгсэлд хийсэн шатахууны зардалд замын хуудас байхгүй, жолоочийн тооцоо бодоогүй	9920.0	Зөвлөмж өгөх		
3	Татварын тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчин И баримтаар нотлогдоогүй ажил гүйлгээг санхүүжүүлсэн.	00	Зөвлөмж өгөх		
ДҮН		13200.0			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР